



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРЭН АШИГЛААГҮЙ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЯНАЛТЫГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭС ХЭРЭГЖИЛТ УДААШИРЧ ХӨРӨНГИЙН ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА.



**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР НӨЛӨӨ, ҮР ДҮН**

Улаанбаатар хот
2022 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (БНА-2022/30-ШТА-ГА) тайлан, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж дүнг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумьяабазар), дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг аудитын гуравдугаар хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4. Тайланг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, дүүргүүдийн Засаг дарга нар, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус хүргүүлсүгэй.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

| | | |
|--|---|-------|
| Аудитын тайланг бэлтгэсэн: | Товчилсон үг | 4 |
| Нийслэл дэх Төрийн аудитын газар | Хүснэгтийн жагсаалт | |
| Аудитын III хэлтэс | Дүрслэлийн жагсаалт | 5 |
| Хэлтсийн дарга, аудитын менежер: | Хавсралтын жагсаалт | |
| Э.Мөнхмандах | Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл | 6-7 |
| Аудитын менежер: | Ерөнхий мэдээлэл | 8 |
| Аудитор: | Бүлэг 1. | |
| Б.Номинбаатар | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх. | 9-16 |
| С.Анужин | | |
| З.Болд | Бүлэг 2. | |
| Э.Дөлгөөн | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх. | 17-23 |
| Б.Золбаяр | | |
| Т.Шүрэнцэцэг | Бүлэг 3. | |
| Гэрээт ажилтан: | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх | 24-31 |
| Д.Болормаа | | |
| | Аудитын дүгнэлт | 32 |
| | Аудитын зөвлөмж | 33 |
| Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө Г корпус. Утас: 327787 | Ирүүлсэн санал, тайлбар | 34-35 |
| Тайланг https://audit.mn/ веб сайтаас үзнэ үү. | Хавсралтууд | 36-43 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---------------|--|
| ААНБ | Аж ахуй нэгж байгууллага |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| БГД | Баянгол дүүрэг |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| БНД | Багануур дүүрэг |
| БХД | Багахангай дүүрэг |
| ДОНХС | Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан |
| ЗГ | Засгийн газар |
| ЗД | Засаг дарга |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИНХ | Иргэдийн нийтийн хурал |
| МУЗЗНДТУТХ | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль |
| НД | Налайх дүүрэг |
| НДАГ | Нийслэлийн дотоод аудитын газар |
| НЗД | Нийслэлийн Засаг дарга |
| НЗДТГ | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| НИТХ | Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НӨХГ | Нийслэлийн өмчийн харилцааны газар |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| НХААГ | Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар |
| НОНХС | Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| СС | Сангийн сайд |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| СЯ | Сангийн яам |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |
| ТТХ | Төсвийн тухай хууль |
| УИХ | Улсын Их Хурал |
| УМС | Удирдлага мэдээллийн систем |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ХААА | Худалдан авах ажиллагааны алба |
| ХУД | Хан-Уул дүүрэг |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| ЭЗТХ | Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс |

Хүснэгтийн жагсаалт

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|-------------|--|-----------------|
| Хүснэгт №1 | ОНХС-ийн эх үүсвэр | 8 |
| Хүснэгт №2 | Өмнөх оны үлдэгдэл зөрүү | 9 |
| Хүснэгт №3 | ОНХНС-ийн эх үүсвэр | 9 |
| Хүснэгт №4 | ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг | 10 |
| Хүснэгт №5 | НОНХС-аас ДОНХС-д тооцож олгосон орлогын шилжүүлэг | 11 |
| Хүснэгт №6 | 2021 оны ДОНХС-д олгосон санхүүжилт | 11 |
| Хүснэгт №7 | ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нд өгсөн иргэдийн оролцоо санал | 12 |
| Хүснэгт №8 | ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлт | 14 |
| Хүснэгт №9 | ТАХ-г НЗД-ын захирамжаар задалсан байдал | 14 |
| Хүснэгт №10 | Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ | 16 |
| Хүснэгт №11 | Тухайн онд багтаж хэрэгжээгүй ТАХ | 17 |
| Хүснэгт №12 | ТАХ-ний хэрэгжилтийн байдал | 19 |
| Хүснэгт №13 | НОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, санхүүжилт олгосон байгууллагууд | 24 |
| Хүснэгт №14 | ДОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажилд захиалагчийн хяналт тавьж санхүүжилт олгосон байгууллагууд | 25 |
| Хүснэгт №15 | Хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс бүртгэлд тусгасан байдал | 28 |
| Хүснэгт №16 | УМС-д мэдээлэл оруулсан байдал | 28-29 |
| Хүснэгт №17 | Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцруулж оруулсан дүүргүүд | 29 |

Дүрслэлийн жагсаалт

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|------------|---|-----------------|
| Дүрслэл №1 | ХАА зохион байгуулах эрхийг шилжүүлсэн байгууллагаар нь харуулбал | 17 |
| Дүрслэл №2 | Нийслэл, дүүргийн 2021 онд олгосон нийт санхүүжилт | 18 |

Хавсралтын жагсаалт

| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|-------------|---|-----------------|
| Хавсралт №1 | НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар зураг төсөвгүй батлагдсан ТАХ-ний жагсаалт | 35-37 |
| Хавсралт №2 | ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар зураг төсөвгүй батлагдсан ТАХ -ний жагсаалт | 37-38 |
| Хавсралт №3 | ХАА-ны зөрчлийн нэгтгэл | 38-40 |
| Хавсралт №4 | НТАГ, НДАГ, Дүүргүүдийн өгсөн зөвлөмж | 41 |
| Хавсралт №5 | Хэрэгжиж дууссан боловч өмчид бүртгээгүй ажлын жагсаалт | 42 |

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/29 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, Нийслэл дэх Төрийн Аудитын газрын 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хийв.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад НЗДТГ-ын СТСХ, ХБТХ, 9 дүүргийн ЗДТГ-ын ДБТХ, СТСХ, ЭЗТХ, ХААА зэрэг хэлтэс, албадыг хамруулан ОНХС-ийн 2021 оны төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, өмнөх онуудаас дамжин хэрэгжих болон шинээр эхлэх ажлуудын санхүүжилт, гэрээний хэрэгжилтийг түүвэрлэн хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг Төрийн Аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим” MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020, “МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитад Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХ, Барилгын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон МУ-ын ЗГ-ын 2016 оны 153, 2017 оны 230 дугаар тогтоол, СС-ын 2012 оны “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2018, 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”, нийслэл, дүүргийн ИТХ, ЗД-ын тогтоол, захирамж, шийдвэр холбогдох бусад эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болголоо.

| | |
|--|---|
| <p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p> | <p>Аудитыг аудитын 3 дугаар хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Номинбаатар хэрэгжүүлж, аудитор С.Анужин, З.Болд, Э.Дөлгөөн, Б.Золбаяр, Т.Шүрэнцэцэг, гэрээт ажилтан Д.Болормаа нар гүйцэтгэв. Аудитыг 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл хэрэгжүүлэв.</p> |
| <p>Аудитын явцад үүссэн хүндрэл бэрхшээл</p> | <p>Тус аудитын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн дэд хөтөлбөрийг 2022 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр батлуулж, гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 5 дугаар сарын 19-ний өдөр хүртэл буюу 1 сарын хугацаанд аудитыг гүйцэтгэсэн нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байсан.</p> |

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн 2021 оны хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 2021 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйл, СС-ын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан журмын 8.8-д заасны дагуу өмнөх оны үлдэгдэл санхүүжилтээр 11,900.0 сая төгрөг, ОНХНС-ын шилжүүлэг 33,036.2 сая төгрөг, нийт 2 төрлийн эх үүсвэрээс 44,936.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

НОНХС-ийн орлогын хэмжээг Төсвийн тухай хуульд заасны дагуу НИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 02/11 дугаар тогтоолоор баталж, 2021 оны 10 дугаар сарын 7-ны III-03/28 болон 10 дугаар сарын 28-ны өдрийн 10/29 дугаар тогтоолоор тодотгол хийсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 30,571.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 251 ТАХ-г төлөвлөжээ.

ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17,242.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 199 ТАХ он дамжсан, 31,224.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 284 ТАХ шинээр хэрэгжих, нийт 42,984.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 483 ТАХ нь захирамжаар задарч 548 ТАХ болж, 275 ТАХ буюу 50.1% хэрэгжсэн, 162 ТАХ буюу 29.6% дутуу хэрэгжсэн, 111 ТАХ буюу 20.3% хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ 1. ОНХС-ИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ХУВААРИЛСАН ЭСЭХ.

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулсан боловч хуульд заасан эх үүсвэрээр төлөвлөж бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх боломжийг ашиглаагүй, зөвхөн ОНХС-аас шилжүүлсэн орлогыг хуваарилжээ.

1.1. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг хуульд заасан эх үүсвэрээр бүрэн төлөвлөөгүйгээс бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх боломжийг ашиглаагүй, ОНХС-аас НОНХС-д, НОНХС-аас ДОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна.

1.1.1. ОНХС-ийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлсэн үү?

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгө нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасны дагуу дараах эх үүсвэрээс бүрдэхээр заажээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;
- Хуулийн 59.2-т заасан хөрөнгө;
- Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;
- Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.
- Ашигт малтмалын тухай хуулийн 47³дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь
- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь.
- Малын тоо толгойн албан татварын орлого.

2021 онд нийслэл, дүүргийн ОНХС-д дээрх эх үүсвэрүүдээс 2 төрлийн эх үүсвэр буюу өмнөх оны үлдэгдэл санхүүжилтээр 11,900.0 сая төгрөг, ОНХС-ын шилжүүлэг 33,036.2 сая төгрөг, нийт 44,936.2 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Хүснэгт №1. ОНХС-ийн эх үүсвэр

/сая.төг/

| № | Нэр | Нийт санхүүжилт | Үүнээс | |
|----|-------------|-----------------|--------------------|-------------------|
| | | | Өмнөх оны үлдэгдэл | ОНХС-ын шилжүүлэг |
| 1 | Нийслэл | 33,011.5 | 9,948.5 | 23,063.0 |
| 2 | БГД | 1,014.5 | 41.7 | 972.8 |
| 3 | БЗД | 3,040.7 | 807.3 | 2,233.4 |
| 4 | БНД | - | - | 1,098.7 |
| 5 | БХД | - | - | 190.1 |
| 6 | НД | 839.4 | 16.7 | 822.7 |
| 7 | СБД | 862.7 | 136.7 | 726 |
| 8 | СХД | 2,171.8 | 27.1 | 2,144.7 |
| 9 | ХУД | 1,446.2 | 651 | 795.2 |
| 10 | ЧД | 1,260.3 | 270.7 | 989.6 |
| | Нийт | 44,936.2 | 11,900.0 | 33,036.2 |

Нийт ОНХС-ийн эх үүсвэрийн 26.4%-ийг өмнөх оны үлдэгдэл санхүүжилт, 73.6%-ийг ОНХНС-ийн орлогын шилжүүлгээр бүрдүүлсэн байна.

Харин зарим дүүрэгт малын тоо толгойн албан татварын орлого бүрдсэн боловч ДОНХС-ийн дансанд шилжүүлээгүй байна. Тухайлбал:

- БНД нь малын тоо, толгойн албан татварын орлогын эх үүсвэрээс 60.0 саяар төлөвлөж бүрдсэн.
- БЗД төлөвлөөгүй боловч 3.9 сая төгрөгийг бүрдүүлж ДОНХС-д шилжүүлээгүй байна.

СС-ын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан журмын 8.8¹-д заасны дагуу тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар батлуулдаг байна.

Нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоолоор өмнөх оны үлдэгдлийг 11,900.0 сая төгрөг гэж баталсан боловч ОНХС-ийн дансны үлдэгдлийг тулгахад 11,641.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу 258.2 сая төгрөгийн зөрүүтэй байна.

Хүснэгт №2. Өмнөх оны үлдэгдэл зөрүү

/сая.төг/

| № | Нэр | ИТХ-ын тогтоолоор | Дансны үлдэгдэлээр | Зөрүү үнийн дүн |
|-------------|---------|-------------------|--------------------|-----------------|
| 1 | Нийслэл | 9,948.5 | 9,489.7 | 458.8 |
| 2 | БГД | 41.7 | 41.7 | 0 |
| 3 | БЗД | 807.3 | 746.8 | 60.5 |
| 4 | БНД | - | - | - |
| 5 | БХД | - | 9.5 | -9.5 |
| 6 | НД | 16.7 | 40.9 | -24.2 |
| 7 | СБД | 136.7 | 102.6 | 34.1 |
| 8 | СХД | 27.1 | 404 | -376.9 |
| 9 | ХУД | 651 | 613.5 | 37.5 |
| 10 | ЧД | 270.7 | 193.1 | 77.6 |
| Нийт | | 11,900.0 | 11,641.8 | 258.2 |

Бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн байдлыг харвал ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-аас орох төлбөрийг улсын төсөвт шууд татан төвлөрүүлдэг учир нийслэл, дүүрэгт тооцоолол хийгддэггүй, СЯ-ны бүрдүүлэлтээр шилждэг байна.

Хүснэгт №3. ОНХНС-ийн эх үүсвэр

/сая.төг/

| № | Эх үүсвэр | Мөнгөн дүн |
|-------------|--|-----------------|
| 1 | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын - 5 хувь | 20,781.9 |
| 2 | Дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын - 5 хувь | 10,301.1 |
| 3 | Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын - 30 хувь | 1,913.0 |
| 4 | Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл /100 хувь/ | 6.3 |
| 5 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл /50 хувь/ | 33.9 |
| НИЙТ | | 33,036.2 |

НОНХС-гийн эх үүсвэрт хамаардаг ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн орлого 6.3 сая, ашиглалтын тусгай зөвшөөрлийн орлого 33.9 сая буюу нийт 40.2 сая төгрөг 2021 онд бүрдэж, ОНХНС-д төвлөрч “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг” эх үүсвэрээр шилжигджээ.

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн зарим эх үүсвэрээс тухайлбал, хандив тусламжийн орлого байхгүй, малын албан татварын орлого төлөгддөггүй тул төлөвлөдөггүй зэргээс шалтгаалан хуульд заасан эх үүсвэр тус бүрээр орлогыг бүрдүүлэх боломжгүй байна.

¹ 8.8.ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ.

Нийслэл, дүүргийн ОНХС-г хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгийг хуульд заасан зарим эх үүсвэрээр бүрдүүлжээ.

1.1.2. ОНХС-аас нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилж олгосон уу?

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд ОНХС-аас НОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 33,036.2 сая төгрөгөөр баталсан.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2², МУ-ын ЗГ-ын 2017 оны "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын дагуу СЯ-аас нийслэлийн ОНХС-д тухайн онд олгох орлогын шилжүүлгийг сар бүрийн төлөвлөгөөт хуваарийн дагуу шилжүүлээгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4. ОНХС-аас олгосон орлогын шилжүүлэг

| № | Үзүүлэлт, сар | Төлөвлөгөө | /сая.төг/ | |
|-------------|---------------|-----------------|-------------------------|-----------------|
| | | | Сангийн яамны шилжүүлэг | |
| 1 | 1 сар | 0 | | 0 |
| 2 | 2 сар | 1,563.8 | | 780.6 |
| 3 | 3 сар | 2,502.1 | | 1570.4 |
| 4 | 4 сар | 3,135.6 | | 2433.3 |
| 5 | 5 сар | 3,127.6 | | 3288.2 |
| 6 | 6 сар | 2,502.1 | | 2590.3 |
| 7 | 7 сар | 3,137.6 | | 2590.3 |
| 8 | 8 сар | 2,502.1 | | 5171.8 |
| 9 | 9 сар | 2,502.1 | | 5101.1 |
| 10 | 10 сар | 6,423.6 | | 0.53 |
| 11 | 11 сар | 2,502.1 | | 4237.3 |
| 12 | 12 сар | 3,137.6 | | 5271.8 |
| Нийт | | 33,036.2 | | 33,036.2 |

Дүгнэлт: ОНХС-аас нийслэлийн ОНХС-ийн орлогын шилжүүлгийг сар бүрийн төлөвлөгөөт хуваарийн дагуу шилжүүлээгүй байна.

1.1.3. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгосон уу?

НОНХС-аас ДОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хуваарийг НЗД-ын 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн А/10 дугаар захирамжаар 9,973.2 сая төгрөг баталсан.

Тус хуваарьт СС-ын 2021 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 113 дугаар тушаалаар өөрчлөлт оруулснаар НЗД-ын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/791 захирамжаар өөрчлөлт оруулжээ.

НОНХС-аас ДОНХС-д олгох 9,973.2 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7³-д заасан ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2021 оны төсвийн жилд 50%, ЗГ-ын 2017 оны "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын 8⁴-д заасны дагуу хүн амын тооны үзүүлэлтэд 40%, алслалтын байдал болон нутаг дэвсгэрийн хэмжээний үзүүлэлтэд тус тус 30%-иар харгалзуулан тооцсон байна.

² 59.2.2.энэ зүйлийн 59.2.1-д зааснаас бусад хэсгийн 50-аас доошгүй хувийг хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилах;

Хүснэгт № 5. НОНХС-аас ДОНХС-д тооцож олгосон орлогын шилжүүлэг

| Хуваарилсан үзүүлэлт | | ДОНХС-д хуваарилах | | | | | | | | /сая.төг/ Нийт | |
|---------------------------------|-------------------------------|--------------------|----------------|----------------|--------------|--------------|--------------|----------------|--------------|-------------------|----------------|
| Амхбатз-ийн төлбөрийн 50% | | БГД | БЗД | БНД | БХД | НД | СБД | СХД | ХУД | ЧД | |
| | | 0 | 0.6 | 5.8 | 0.6 | 4.8 | 0.3 | 1.6 | 7.5 | 0 | 21.2 |
| Итгэлцүүрээр хуваарилах | Алслагдсан байдал (30%) | 337.3 | 525.1 | 575.5 | 82.9 | 243.9 | 212.2 | 502.6 | 259.2 | 246.9 | 2985.6 |
| | Хүн амын тоо (40%) | 602.7 | 933.1 | 117.4 | 18.0 | 136.0 | 378.3 | 893.1 | 463.0 | 439.1 | 3980.8 |
| | Нутаг дэвсгэрийн хэмжээ (30%) | 32.8 | 774.6 | 399.9 | 88.6 | 437.9 | 135.3 | 747.3 | 65.5 | 303.6 | 2985.6 |
| НОНХС-аас олгох нийт дүн | | 972.8 | 2,233.4 | 1,098.7 | 190.1 | 822.7 | 726.1 | 2,144.8 | 795.2 | 989.6 | 9,973.2 |

НОНХС-аас ДОНХС-д 9,973.2 сая төгрөг шилжүүлэхээр тооцоолж төлөвлөсөн боловч 9,231.9 сая төгрөгийг шилжүүлж, 741.3 сая төгрөгийг дутуу буюу төлөвлөгөөний дагуу шилжүүлээгүй байна.

Хүснэгт № 6. 2021 оны ДОНХС-д олгосон санхүүжилт

| № | Дүүргийн нэр | Төлөвлөгөө | Олгосон санхүүжилт | Дутуу шилжүүлсэн дүн | /сая.төг/ |
|---|--------------|------------|--------------------|----------------------|--------------|
| 1 | БГД | | 972.8 | 900.5 | 72.3 |
| 2 | БЗД | | 2,233.4 | 2,067.4 | 166.0 |
| 3 | БНД | | 1,098.7 | 1,017.0 | 81.7 |
| 4 | БХД | | 822.7 | 761.5 | 61.2 |
| 5 | НД | | 190.1 | 176.0 | 14.1 |
| 6 | СБД | | 726.0 | 672.1 | 54.0 |
| 7 | СХД | | 2,144.7 | 1,985.3 | 159.4 |
| 8 | ХУД | | 795.2 | 736.1 | 59.1 |
| 9 | ЧД | | 989.6 | 916.1 | 73.6 |
| | Дүн | | 9,973.2 | 9,231.9 | 741.3 |

ОНХС-аас хуваарилагдаж орж ирсэн орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн шилжүүлээгүйгээс тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим ТАХ хэрэгжих боломжгүй нөхцөл үүсчээ.

НОНХС-аас ДОНХС-д олгох санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олгох шаардлагатай байна.

Дүгнэлт: НОНХС-аас ДОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна.

1.1.4. Нийслэл, дүүргийн ОНХС-д хуулиар олгогдох эх үүсвэрийн боломжийг судалж, орон нутгийн хөгжлийн санд нэмж төлөвлөж чадаж байна уу?

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасны дагуу ОНХС бүрдүүлэх эх үүсвэрүүдийг хуульчилсан. Эдгээр эх үүсвэрээс малын тоо толгойн албан татварын орлогыг БНД бүрдүүлэхээр төлөвлөж, бусад дүүрэг нь төлөвлөдөггүй байна. Гүйцэтгэлээр БЗД 3.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь дүүргүүдэд малын тоо, толгойн албан татварын орлогыг бүрдүүлэх боломжийг судлаагүй байна.

Нийслэл, дүүргийн ОНХС-д төвлөрүүлэх орлогыг хуульд заасан эх үүсвэрээр бүрдүүлж байгаа боловч эх үүсвэр тус бүрээр бүрдүүлэх ажил хангалтгүй, нэмэлт эх үүсвэрээр төлөвлөх тооцоо судалгааг нийслэл, дүүргээс хийгээгүй байна.

Цаашид хуульд заасан эх үүсвэр тус бүрээр ОНХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх боломжийг судалж орлогыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг бүрэн ашиглаж, төлөвлөж чадаагүй байна.

1.2. Нийслэл, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн үү?

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г иргэдийн 18.4-101.4%-ийн оролцоотойгоор саналыг авч, 95.2%-иар эрэмбэлж, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөжээ.

1.2.1. Шат, шатны төсвийн захирагчид ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналыг хүртээмжтэй байдлаар авч эрэмбэлсэн үү?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө СС-ын 2018 оны 228 дугаар журмын 3.1.2⁵, 5.2⁶, 5.2.3⁷, 5.5⁸-т заасны дагуу зохион байгуулахаар тусгажээ.

Нийслэл, дүүргийн ЗДТГ нь “Ковид-19” цар тахлаас шалтгаалан 2021 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний саналыг “Smart UB” цахим программ ашиглан 18-аас дээш насны 349,056 иргэдээс авсан байна.

Хүснэгт №7. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-нд өгсөн иргэдийн оролцоо санал

| № | Дүүргийн нэр | Нийт тоо | Санал өгсөн тоо | Оролцоо /хувь/ | НОНХС | | | ДОНХС | | | /хүн.тоо/ |
|---|--------------|----------------|-----------------|----------------|-----------------------|----------------|--------------|-----------------------|----------------|--------------|-----------|
| | | | | | Цахим саналын | | | | | | |
| | | | | | Нийт тоо /давхардсан/ | Батлагдсан тоо | Хувь | Нийт тоо /давхардсан/ | Батлагдсан тоо | Хувь | |
| 1 | БГД | 130,413 | 32,245 | 24.7% | 129,230 | 100,930 | 78.1% | 129,233 | 60,376 | 46.7% | |
| 2 | БЗД | 211,048 | 38,870 | 18.4% | 138,247 | 103,259 | 74.7% | 134,717 | 19,487 | 14.5% | |
| 3 | БНД | 19,578 | 11,391 | 58.2% | 38,287 | 22,469 | 58.7% | 38,287 | 8,389 | 21.9% | |
| 4 | БХД | 2,625 | 2,662 | 101.4% | 6,492 | 2,696 | 41.5% | 6,668 | 1,518 | 22.8% | |
| 5 | НД | 23,791 | 22,446 | 94.3% | 88,119 | 49,097 | 55.7% | 61,058 | 43,621 | 71.4% | |
| 6 | СБД | 66,849 | 46,180 | 69.1% | 188,755 | 141,623 | 75.0% | 183,787 | 72,152 | 39.3% | |
| 7 | СХД | 190,056 | 90,096 | 47.4% | 391,906 | 278,488 | 71.1% | 368,127 | 87,031 | 23.6% | |
| 8 | ХУД | 92,540 | 47,520 | 51.4% | 172,351 | 105,999 | 61.5% | 175,816 | 22,023 | 12.5% | |
| 9 | ЧД | 68,672 | 57,646 | 83.9% | 161,570 | 90,840 | 56.2% | 154,334 | 105,409 | 68.3% | |
| | Нийт | 805,572 | 349,056 | 43.3% | 1,314,957 | 895,401 | 68.1% | 1,252,027 | 420,006 | 33.5% | |

Дээрх хүснэгтээс харахад хүн амын тоо, нутаг дэвсгэрийн онцлог бүхий томоохон дүүрэг болох БЗД, БГД, СХД-т санал өгөх иргэдийн оролцоо 18.4-47.4%-д хүрэхгүй, бусад дүүргүүдэд 51.4%-100%, нийт оролцоо 18.4-100%-тай буюу харилцан адилгүй байгаа нь ОНХС-ийн талаарх танилцуулга, мэдээлэл хүртээмжтэй хүрч байгаа эсэх нь тодорхойгүй байна.

НОНХС, ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр нийт 2,566,984 цахим санал буюу давхардсан тоогоор 1,315,407 цахим санал ирүүлснээс холбогдох хууль, журмын дагуу эрэмбэлэгдсэн 30,034.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 239 ТАХ байна.

Харин зураг төсөл боловсруулах 537.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ буюу 4.8% нь СС-ын 2018 оны 228 дугаар журмын 3.1.2⁹-т заасантай нийцээгүй буюу эрэмбэлэгдээгүй ТАХ батлагджээ.

⁵ 3.1.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

⁶ 5.2 Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг дараах хэлбэрээр явуулна. Үүнд:

7 5.2.3 цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэр;

8 5.5.Энэ журмын 5.2.3-т заасан арга хэлбэрээр санал авах тохиолдолд 30-аас доошгүй хоногийн турш тогтсон цахим хаяг, цахим хуудсаар саналыг хүлээн авах бөгөөд саналыг 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу нэгтгэн баталгаажуулна.

⁹ 3.1.2 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

Мөн тухайн дүүргийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн ТАХ-г СС-ын 2018 оны 228 дугаар журмын 3.1.5¹⁰-т заасны дагуу өөр бусад эх үүсвэртэй уялдуулж төлөвлөсөн байна. Тухайлбал:

СБД-т “Гудамж талбайн камержуулалт хийх” ТАХ иргэдээс хамгийн олон санал буюу 30,541 санал авч 1 дүгээрт эрэмбэлэгдсэн хэдий ч журмын дагуу ДТХО-аар 96.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хэрэгжүүлэхээр шилжүүлэн тусгасан байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г төлөвлөхөд иргэд 18.4-101.4%-тай хамрагдаж, ТАХ-ний 95.2% нь эрэмбэлэгджээ.

1.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г СС-ын 2018 оны 228 дугаар тушаалын 3.1.1¹¹, 6.4.2¹², 7.2.1¹³-т заасны дагуу хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөхөөр заажээ.

2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх ТАХ-г “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “ДЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон тухайн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн төлөвлөжээ.

Мөн ХБТТУТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.9¹⁴-д богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг буюу хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар тусгасан. Тус хуулийн хүрээнд НИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний 02/10 дугаар “НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” тогтоолын 2.4¹⁵ дэх хэсэгт “Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г боловсруулж НИТХ-д хуралд өргөн мэдүүлэхийг НЗД-д даалгасан ч “МУ-ын 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө” батлагдаагүй шалтгаанаар “Нийслэлийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөө”-г батлуулаагүй байна.

Шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ нь хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаж байгаа ч цаашид ТАХ-ний саналыг боловсруулахдаа хэтийн төлөвлөгөө, бүс орон нутгийн онцлогт нийцүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулжээ.

1.2.3. Нийслэл, дүүргийн ОНХС-аас тухайн шатны чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг тусгасан уу?

Нийслэл, дүүргийн ОНХС-аас шинээр хэрэгжүүлэхээр баталсан 251 ТАХ-нээс 239 ТАХ буюу 95.2% нь тухайн шатны чиг үүрэгт хамаарах ТАХ-г тусган баталжээ.

Харин 537.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ буюу 4.8% нь тухайн шатны чиг үүрэгт хамаарахгүй ТАХ байна. Тухайлбал: Зураг төсөл боловсруулах ажлын зардал байна.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн ОНХС-аас шинээр хэрэгжүүлэхээр баталсан ТАХ-ний 95.2% нь тухайн шатны чиг үүрэгт хамаарах ТАХ байна.

¹⁰ 3.1.5.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй уялдуулан төлөвлөсөн байх;

¹¹ 3.1.1.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх;

¹² 6.4.2.Сум, дүүргийн хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан эсэх;

¹³ 7.2.1.Тухайн аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөө;

¹⁴ 6.9 Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөв хамаарна;

¹⁵ 2.4 Монгол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө батлагдсаны дараа түүнд суурилсан Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулж Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлэх

1.2.4. Нийслэл, дүүрэг, хорооны түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг бусад хууль журмын дагуу төлөвлөсөн үү?

2021 онд НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 21,385.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 143 багц ТАХ, ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 9,186.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 108 багц нийт 30,571.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 251 ТАХ шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Анх төлөвлөгдөж батлагдсан ТАХ-нд 1-7 удаа төсвийн тодотгол хийгдэж НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 21,385.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 155 багц ТАХ, ДОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 9,839.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 129 багц нийт 31,224.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 284 ТАХ болж нэмэгдсэн байна.

Хүснэгт №8. ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлт

| № | Тогтоолын утга | НИТХ-ын 2021 оны төсөв батлах тухай тогтоол | | Тогтоолын зөрүү | | НИТХ-ын сүүлийн тодотгол | | ДИТХ-ын 2021 оны төсөв батлах тухай тогтоол | | Тогтоолын зөрүү | | ДИТХ-ын сүүлийн тодотгол | |
|-----------------|----------------|---|-----------------|-----------------|--------------|--------------------------|-----------------|---|----------------|-----------------|--------------|--------------------------|----------------|
| | | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг |
| 1 | БГД | 20 | 2,400.0 | - | - | 20 | 2,400.0 | 5 | 800.0 | 1 | 74.5 | 6 | 874.5 |
| 2 | БЗД | 25 | 4,000.0 | 1 | - | 26 | 4,000.0 | 24 | 2,116.4 | - | 117 | 24 | 2,233.4 |
| 3 | БНД | 4 | 800.0 | - | - | 4 | 800.0 | 5 | 892.8 | 3 | 115 | 8 | 1,007.8 |
| 4 | БХД | 3 | 400.0 | - | - | 3 | 400.0 | 5 | 149.4 | - | 9.5 | 5 | 158.9 |
| 5 | НД | 2 | 800.0 | 1 | - | 3 | 800.0 | 22 | 668.8 | 8 | 91.9 | 30 | 760.7 |
| 6 | СБД | 12 | 1,600.0 | -2 | - | 10 | 1,600.0 | 16 | 688 | 1 | 38 | 17 | 726.0 |
| 7 | СХД | 36 | 4,000.0 | 17 | - | 53 | 4,000.0 | 8 | 2,058.5 | 6 | 113.3 | 14 | 2,171.8 |
| 8 | ХУД | 22 | 2,400.0 | -1 | - | 21 | 2,400.0 | 2 | 753.5 | - | 41.7 | 2 | 795.2 |
| 9 | ЧД | 17 | 1,640.0 | -4 | - | 13 | 1,640.0 | 21 | 1,059.1 | 2 | 51.9 | 23 | 1,111.0 |
| 10 | Бусад | 1 | 3,139.4 | - | - | 1 | 3,139.4 | - | - | - | - | - | - |
| 11 | Суурь зардал | 1 | 205.9 | - | - | 1 | 205.9 | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | | 143 | 21,385.3 | 12 | - | 155 | 21,385.3 | 108 | 9,186.5 | 21 | 652.8 | 129 | 9,839.3 |

ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ-нээс 4,775.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нэр, байршил нь ерөнхий байдалтай 7 багц ТАХ нь дахин нэр, байршил, төсөвт өртгийг өөрчилж 49 ТАХ болгож захирамжаар задалсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4-т “санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран төсөл арга хэмжээ нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах” гэж заасныг зөрчжээ. Тухайлбал:

НОНХС-ийн хөрөнгөөр СБД-т хэрэгжих 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил” ТАХ-г 5 болгон задалж захирамжилсан.

Хүснэгт №9. ТАХ-г НЗД-ын захирамжаар задалсан байдал

| № | ТАХ-ний нэр, хүчин чадал, байршил | Эхлэх, дуусах хугацаа | Төсөвт өртөг | № | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Эхлэх, дуусах хугацаа | Төсөвт өртөг |
|---|--|-----------------------|--------------|---|--|-----------------------|--------------|
| | | | | | | | |
| 1 | Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил /СБД/ | 2021 | 400 | 1 | 41 дүгээр байрны дээвэр засвар /СБД, 3 дугаар хороо/ | 2021 | 80.0 |
| | | | | 2 | 22 дугаар байрны дээвэр засвар /СБД, 5 дугаар хороо/ | | 80.0 |
| | | | | 3 | 39 дүгээр байрны гадна фасад засвар /СБД, 10 дугаар хороо/ | | 80.0 |
| | | | | 4 | 16 дугаар байрны гадна фасад засвар /СБД, 10 дугаар хороо/ | | 80.0 |
| | | | | 5 | 33 дугаар байрны гадна фасад засвар /СБД, 10 дугаар хороо/ | | 80.0 |

2021 онд шинээр хэрэгжих 14,284.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 121 ТАХ-г зураг төсөвгүй баталжээ. *Хавсралт 1, 2.* Тухайлбал:

- “Гэрэлтүүлгийн ажил /БЗД, 2, 4 дүгээр хороо/” 330.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэг /БЗД, 8, 10, 13, 14, 17 дугаар хороо/” 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ;
- “Явган хүний зам засвар, шинэчлэл, тохижилтын ажил” 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ байна.

Нийслэл, дүүргийн ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-г батлахдаа нэр, төсөвт өртөг тодорхойгүй, ерөнхий нэрээр зураг төсөвгүй баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4¹⁶, 29.4¹⁷, СС-ын 2018 оны 228 дугаар журмын 3.1.3¹⁸ -д заалтыг тус тус зөрчсөн байна.

Энэ нь ТАХ хугацаандаа хэрэгжихгүй байх, төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулах эрсдлийг бий болгож байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим ТАХ-г хууль, журмын дагуу төлөвлөөгүй байна.

¹⁶ 29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

¹⁷ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹⁸ 3.1.3.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЖУРМЫН ДАГУУ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭСЭХ

ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17,242.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 199 ТАХ он дамжсан, 31,224.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 284 ТАХ шинээр хэрэгжих, нийт 42,984.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 483 ТАХ нь захирамжаар задарч 548 ТАХ болж, 275 ТАХ буюу 50.1% хэрэгжсэн, 162 ТАХ буюу 29.6% дутуу хэрэгжсэн, 111 ТАХ буюу 20.3% хэрэгжээгүй байна.

2.1. Нийслэл, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг баримталсан уу?

Аудитын түүвэрт хамрагдсан 178 ТАХ-ээс 27 ТАХ буюу 15.2%-ийн худалдан авах ажиллагааг хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй байна.

2.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр нийслэл, дүүрэгт бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулсан уу?

2021 онд НОНХС-ийн хөрөнгөөр 23,318.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 215 ТАХ, ДОНХС-ийн хөрөнгөөр 12,270.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 119 ТАХ, он дамжих 1,944.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 ТАХ нийт 37,534.30 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 365 ТАХ-ийг ХАА-г нийслэл, дүүрэгт эрх шилжүүлжээ.

Хүснэгт №10. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ


/сая.төг/

| № | Байгууллагын нэр | Эрх шилжүүлсэн | | Гэрээ байгуулагдсан ТАХ | | | Хэмнэлт |
|-------------|------------------|----------------|-----------------|-------------------------|-----------------|-----------------|----------------|
| | | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Гэрээний дүн | |
| 1 | НАЗХГ | 2 | 475.0 | 2 | 475.0 | 464.5 | 10.5 |
| 2 | НХААГ | 84 | 7,069.1 | 49 | 4,551.9 | 4,309.6 | 242.3 |
| 3 | УБЗАА | 47 | 4,504.3 | 11 | 1,081.6 | 1,031.2 | 50.4 |
| 4 | БГД ХААА | 26 | 3,038.5 | 18 | 2,151.6 | 2,035.1 | 116.5 |
| 5 | БЗД ХААА | 49 | 6,393.9 | 32 | 5,442.9 | 4,557.2 | 885.7 |
| 6 | БНД ХААА | 11 | 1,842.8 | 8 | 1,672.8 | 1,580.6 | 92.2 |
| 7 | БХД ХААА | 8 | 573.9 | 8 | 573.9 | 530.2 | 43.7 |
| 8 | НД ХААА | 14 | 1,031.7 | 12 | 970.2 | 936.7 | 33.5 |
| 9 | СБД ХААА | 27 | 1,606.9 | 23 | 1,162.3 | 1,133.6 | 28.7 |
| 10 | СХД ХААА | 31 | 4,424.9 | 22 | 3,547.0 | 3,210.0 | 337 |
| 11 | ХУД ХААА | 24 | 3,143.7 | 16 | 2,453.0 | 2,259.1 | 193.9 |
| 12 | ЧД ХААА | 31 | 2,189.6 | 18 | 1,296.8 | 1,179.1 | 117.7 |
| 13 | НХОГ ОНӨААТҮГ | 11 | 1,240.0 | 10 | 840.0 | 807.3 | 32.7 |
| Нийт | | 365 | 37,534.3 | 229 | 26,219.1 | 24,034.2 | 2,184.8 |

Нийт эрх шилжсэн ТАХ-нээс 83.6% буюу 31,315.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 305 ТАХ-г ТБОНӨХБАҮХАТХ-ийн 53 дугаар зүйлийн 53.2¹⁹-т заасны дагуу мэргэжлийн байгууллага буюу НХААГ болон дүүргүүдийн ХААА-нд эрхийг шилжүүлсэн байна.

¹⁹ 53.2.Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжтэй байна.

Дүрслэл № 1. ХАА зохион байгуулах эрхийг шилжүүлсэн байгууллагаар нь харуулбал



ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд эрх шилжүүлсэн 365 ТАХ-ээс 62.7% буюу 26,219.1 сая төгрөгийн төсөвтэй 229 ТАХ-ний ХАА-г тухайн онд багтаан зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна. Үүнийг ХАА-ны мөрдөгдсөн журмаар харуулбал:

- 48.9% буюу 112 ТАХ-г харьцуулалтын арга;
- 45.8% буюу 105 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалтын арга;
- 3.2% буюу 7 ТАХ-г зөвлөх үйлчилгээний арга;
- 2.1% буюу 5 ТАХ-г гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулжээ.

Харин тухайн онд багтаж гэрээ хийгдээгүй 37.3% буюу 11,314.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 136 ТАХ дараах шалтгаанаар хэрэгжээгүй байна.

Хүснэгт №11. Тухайн онд багтаж хэрэгжээгүй ТАХ

| № | Хэрэгжээгүй шалтгаан | Хэрэгжээгүй ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Эзлэх жин /хувиар/ |
|-------------|---|-------------------------|-----------------|--------------------|
| 1 | Захирамжаар хүчингүй болсон | 24 | 2,126.4 | 17.6% |
| 2 | Хөрөнгө татагдсан | 16 | 1,017.8 | 11.8% |
| 3 | Газрын асуудал шийдвэрлэгдээгүй | 8 | 766.7 | 5.8% |
| 4 | Зураг төсөв, ажлын даалгаваргүй | 15 | 1,505.8 | 11.1% |
| 5 | Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа | 10 | 398.1 | 7.4% |
| 6 | Тендерийн материал хүлээн авч байгаа | 22 | 1,452.9 | 16.1% |
| 7 | Тендерийн үнэлгээ хийгдэж байгаа | 16 | 925.7 | 11.8% |
| 8 | Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлсэн | 25 | 3,121.0 | 18.4% |
| Нийт | | 136 | 11,314.4 | 100% |

Дээрх хүснэгтээс харахад 2,126.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 ТАХ нь захирамжаар хүчингүй болж, 1,017.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-ний хөрөнгө татагдаснаар нийт 3,144.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 ТАХ хэрэгжихгүй болсон байна.

Аудитын түүвэрт ХАА зохион байгуулж, гүйцэтгэгч сонгон шалгарсан 26,219.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 229 ТАХ-нээс 178 буюу 78%-ийг хамруулан шалгахад дараах зөрчлүүд илэрсэн. *Хавсралт 3. Тухайлбал:*

- *Ерөнхий нөхцөлийг магадлах шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй-2;*
- *Санхүүгийн чадавхын шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй-3;*
- *Техникийн чадавх болон туршлагыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй-14;*
- *Тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл шаардлага-8.*

ХАА-г ил тод нээлттэй, өрсөлдөх тэгш боломжийг ханган зохион байгуулсан ч зарим ТАХ-нд ТББ болон тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан

шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаагүй гүйцэтгэгч шалгаруулжээ.

Тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материалыг хууль, тогтоомжийн хүрээнд үнэлэх, ТАХ-г хэрэгжүүлэх явц, үр дүнд тавих хяналт, шат шатны хариуцлагыг сайжруулахаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.


Дүгнэлт: Нийслэл дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний 15.2% буюу 27-д худалдан авах ажиллагааг хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй байна.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан уу?

Нийслэл, дүүргийн ОНХС-ийн өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдэл 11,641.8 сая төгрөг, ОНХС-аас тухайн жилд олгосон санхүүжилтийн 33,036.2 сая төгрөг нийт 44,678.0 сая төгрөгийн эх үүсвэрээс тодотголоор 42,984.7 сая төгрөгийн 483 ТАХ-нд зарцуулахаар төлөвлөснөөс 23,584.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 371 ТАХ-нд 54.9%-ийн санхүүжилтийг олгожээ.

Дүрслэл №2. Нийслэл, дүүргийн 2021 онд олгосон нийт санхүүжилт

/сая.төг/



ТАХ-нд гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон боловч цаашид анхаарах дараах асуудлууд байна. Тухайлбал:

- Нийт төлөвлөсөн санхүүжилтээс 23,584.5 сая төгрөг буюу 54.9%-ийг нь олгосноос үзэхэд ТАХ-ний хэрэгжилт удаашралтай байгаа нь хөрөнгө зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх эрсдэлтэй;
- Мөн ТАХ-г анх зураг төсөвгүй болон ерөнхий нэр, байршилтайгаар төлөвлөн 1-7 удаагийн төсвийн тодотголын явцад дахин өөрчлөн ИТХ батлах, ЗД захирамжлах зэргээр төсөвлөлтийн шаардлага хангаагүй, зориулалт бус шинжтэй ТАХ-г төлөвлөж, баталж, хэрэгжүүлж байгаа нь дээрх эрсдэлийг дагуулж байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүн, үр нөлөө гарсан уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ нь иргэдийн ая тухтай орчныг бүрдүүлж, орон нутгийн хөгжилд үр дүн үзүүлж байгаа ч төлөвлөсөн зорилтод түвшинд бүрэн хүрээгүйгээс үр нөлөө тодорхойлогдохгүй байна.

2.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшин, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлсон уу?

ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ нь төсвийн тодотгол, ЗД-ын захирамжаар өөрчлөгдөн 548 ТАХ болж задарсан байна.

Хүснэгт №12. ТАХ-ний хэрэгжилтийн байдал

| Д/д | Хэрэгжсэн ТАХ | Батлагдсан ТАХ-ний тоо | Хэрэгжилтийн байдал | | | | | |
|-----|-----------------|------------------------|---------------------|--------------|-----------------|--------------|-----------------|--------------|
| | | | Бүрэн хэрэгжсэн | Хувь | Дутуу хэрэгжсэн | Хувь | Огт хэрэгжээгүй | Хувь |
| 1 | Нийслэл | 366 | 163 | 44.5% | 129 | 35.2% | 74 | 20.3% |
| 2 | БГД | 8 | 4 | 50% | 4 | 50% | - | - |
| 3 | БЗД | 37 | 14 | 37.8% | 10 | 27% | 13 | 35.2% |
| 4 | БНД | 18 | 14 | 77.8% | 2 | 11.1% | 2 | 11.1% |
| 5 | БХД | 8 | 7 | 87.5% | 1 | 12.5% | - | - |
| 6 | НД | 36 | 28 | 77.7% | 7 | 19.4% | 1 | 2.9% |
| 7 | СБД | 21 | 17 | 81% | 2 | 9.5% | 2 | 9.5 |
| 8 | СХД | 22 | 14 | 63.7% | 3 | 13.6% | 5 | 22.7% |
| 9 | ХУД | 4 | - | - | 2 | 50% | 2 | 50% |
| 10 | ЧД | 28 | 14 | 50% | 2 | 7% | 12 | 43% |
| | Нийт дүн | 548 | 275 | 50.1% | 162 | 29.6% | 111 | 20.3% |

Тухайн ондоо хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний БХД 87.5%, СБД 81%, БНД болон НД 77.7%, СХД 63.7%-ийг бүрэн хэрэгжүүлсэн бол, Нийслэл 44.5%, БГД болон ХУД, ЧД 50%-тай, БЗД 38%-тай буюу хэрэгжилт хангалтгүй байна.

ОНХС-ийн дутуу хэрэгжсэн ажлуудын шалтгаан нөхцөлийг тодруулахад дараах байдалтай байна. Үүнд:

- Ковид-19 цар тахлын тархалтын улмаас улсын хил гааль хаагдсанаас шалтгаалан гүйцэтгэгч компаниудын бараа материалын нийлүүлэлт удааширч, ажлууд хойшилсон;
- Бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаалан гэрээний үнийн дүн нэмэгдсэнээс тухайн ТАХ-ний гүйцэтгэгч ажлыг дуусгаж чадахгүйд хүрч гэрээг цуцлах хүртэл хэмжээнд хүрсэн;
- Газар чөлөөлөлтэй холбоотойгоор ажил хойшилсон зэрэг шалтгаантай байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт болон хэрэгжилтийн байдалд нийслэл, дүүргийн хэмжээнд үр дүнг бодитой тодорхойлж тайлагнаагүй байна. Мөн аудитын явцад ТАХ-ний хэрэгжилтийг үзэхэд 50.1%-ийн гүйцэтгэлтэй байгаа нь ТАХ төлөвлөсөн зорилтот түвшинд бүрэн хүрээгүй буюу үр ашиг, үр дүн хангалтгүй байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ төлөвлөсөн зорилтод түвшинд бүрэн хүрээгүй, үр ашиг, үр дүнг бодитой тодорхойлоогүй байна.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлж байна уу ?

СС-ын 2018 оны 228 дугаар журмын 1.1-т “ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ” гэж заажээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “ДЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон тухайн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх зэрэг ТАХ-г хэрэгжүүлснээр иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах эрхийг хангасан бодит үр дүнд хүрсэн байна.

ТАХ-ний гэрээний хэрэгжилтийг түүвэрлэн газар дээр нь тулган баталгаажуулахад дараах ТАХ-нүүд үр дүн багатай байна. Үүнд:

- “Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо, 7 дугаар байрны гадна талбайн тохижилт” 80.4 сая төгрөгийн төсөвтэй ТАХ зураг төсвийн дагуу хийгдсэн боловч нар бага тусах байршилд 1 дор 3 ширхэг сүүдрэвч, 12 ширхэг сандал, 6 ширхэг хогийн савыг хийсэн;
- НД-т хэрэгжих “1-8 хорооны гудамж талбай тэгшлэх” нийт 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ хийж гүйцэтгэсэн боловч буцаад эвдэрч гэмтсэн байгаа нь үр ашиг, үр дүнгүй хөрөнгө оруулалтыг хийснийг харуулж байна.

Зураг 1. “Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо, 7 дугаар байрны гадна талбайн тохижилт” ТАХ



Зураг 2. “1-8 хорооны гудамж талбай тэгшлэх” ТАХ



Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ нь ирээдийн ая тухтай орчныг бүрдүүлж, орон нутгийн хөгжилд бодит үр дүн үзүүлж байгаа ч зарим ТАХ-ний төлөвлөлт, үр дүнд анхаарах шаардлагатай байна.

2.3.ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн байна уу?

МУЗЗНДНТУТХ-ийн 25 дугаар зүйлийн 24.1.2²⁰, 25.1.10²¹, СС-дын 2018 оны 228 дугаар журмын 9.12²²-т заасны дагуу хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт зохицуулагдахаар байна.

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүйгээс зарим хөрөнгө эвдэрч гэмтсэн байна.

2.3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн ашиглалт хэвийн байна уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-нд ашиглагч байгууллагаас тавих хяналт, хамгаалалт хангалтгүйгээс хийгдсэн зарим ажлын тоног төхөөрөмж эвдэрч гэмтсэн байна. Тухайлбал:

- “Дүүргийн нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг худалдан авах /ХУД/” 23.7 сая төгрөгийн төсөвтэй ТАХ. Canon G3060 маркийн өнгөт принтер эвдэрсэн;
- Багц 1 “Дүүргийн эрүүл мэндийн төвд эмнэлгийн компьютер, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл /ХУД/” 47,5 сая төгрөгийн төсөвтэй ТАХ. Өвчтөний

²⁰ 24.1.2.нийслэлийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;

²¹ 25.1.10.нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалт нь дүүргийн чиг үүрэг хамаарна

²² 9.12. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

хяналтын монитормын даралтны аппаратны наадаг зангуу болон пульсоксометр, зүрхний цахилгаан бичлэг хийдэг аппаратны цаас ороогч дамар, увч-30 төхөөрөмжний гарны утас эвдэрсэн;

- “Ахмад настан болон хүүхэд, залуучуудад зориулсан тоглоомын болон биеийн тамир, чийрэгжүүлэлтийн талбай /БЗД, 25 дугаар хороо/” 100.0 сая төгрөгийн төсөвтэй ТАХ. Элсний хайрцаг, 5 ширхэг хогийн савыг байрлуулсныг СӨХ хураасан, савлуур болон 2 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж эвдэрсэн;
- БЗД-т хэрэгжсэн “Тохижилт, бүтээн байгуулалтын ажил /БЗД, 14 дүгээр хороо/” 80.0 сая төгрөгийн төсөвтэй ТАХ. Тоглоомын талбайн резинен будаг ховхорсон, цахилгааны утсыг тог гүйх боломжтой төмөр хашаанд тогтоосон;
- ЧД-ийн нутаг дэвсгэрт хийсэн 682.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй камержуулалтын 15 ТАХ. Камерын хяналтын нэгдсэн дэлгэцийг дүүргийн Цагдаагийн хэлтэст очиж шалгахад зарим камер ажиллахгүй байсан.

Зураг 3. БЗД-г хэрэгжсэн “Тохижилт, бүтээн байгуулалтын ажил /БЗД, 14 дүгээр хороо/” ТАХ



Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон ТАХ-ний ажлын хяналт, хамгаалалт хангалтгүйгээс хийгдсэн зарим ажил эвдэрч гэмтсэн, ашиглалт хэвийн бус байна.

2.3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохистой байна уу?

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг өмчид бүртгэх байгууллага тодорхойгүйгээс хадгалалт, хамгаалалт эзэнгүйдэж эд хөрөнгө эвдрэх, гэмтэх нөхцөл байдал үүсэж байна. Тухайлбал:

- “Зам талбайн засвар, тохижилтын ажил /БЗД, 16, 19, 24 дүгээр хороо/” 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. Шинээр баригдаж буй цэцэрлэгийн барилгын автомашины орц, гарцыг явган хүний зам дээр хийсний улмаас эвдэрсэн;
 - “Хүүхдийн тоглоомын талбай /ЧД, 13 дугаар хороо/” 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. Тоглоомын талбайн будаг ховхорч арилсан, сагсан бөмбөгийн самбарын цагираг алга болсон.
- Аудитын явцад залруулсан зөрчил:

“Харуул Алтай хотхоны гадна талбайн тохижилт /БЗД, 8 дугаар хороо/ 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ. Чийрэгжүүлэх 1 ширхэг төхөөрөмж эвдэрч СӨХ хураасан байсныг засварлуулан байрлуулсан.

Зураг 4. “Хүүхдийн тоглоомын талбай /ЧД, 13 дугаар хороо/”



Зураг 5. “Зам талбайн засвар, тохижилтын ажил /БЗД, 16, 19, 24 дүгээр хороо/”



Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон зарим эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт хангалтгүй байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЯНАЖ, ТАЙЛАГНАСАН ЭСЭХ

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад шат шатны ИТХ нь хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, ЗДТГ хэрэгжилтийн тайланг журамд заасан хугацаанаас хоцроож, УМС, шилэн дансны цахим нэгдсэн хуудаст бүрэн тайлагнаагүй байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажилласан уу?

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад нийслэл болон 6 дүүргийн ИТХ нь хяналтыг хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, зөрчлүүд дахин давтагдаж байна.

3.1.1 Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд тавих хяналтыг хэрэгжүүлж ажилласан уу?

СС-ын 2018 оны 228 дугаар журам, 2021 оны 86 дугаар журмын 9.4²³-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтэд нийслэл, дүүргийн ИТХ дараах байдлаар хяналтыг хэрэгжүүлжээ. Үүнд:

- СБД-ийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар тогтоолоор хөндлөнгийн хяналт хийх зорилго бүхий ажлын хэсэг байгуулжээ. Мөн дүүргийн хороодод 3-5 хүний бүрэлдэхүүнтэй хөндлөнгийн хяналт үнэлгээний багийг байгуулж ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт 16 ТАХ-нд хяналт тавьж ажилласан байна. 2021 оны 11 дүгээр сард бүх хороодын хяналт үнэлгээний багийн тайланг ДИТХ-ын 2022 оны 5 дугаар ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн байна. Хяналтын багын ирүүлсэн тайлангаас үзэхэд дүүргийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний ажлын явц гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлжээ;
- НД-ийн ИТХ-ын 2021 оны А/88 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж, 7 ТАХ-ний гүйцэтгэлийг шалгажээ. Тус ажлын хэсэг гэр хорооллын гудамж талбайг тэгшлэх ажил нь иргэдийн санаа сэтгэлд нийцэж байгаа боловч насжилтгүй, батлагдсан төсөв бага, үерийн усны үеэр ихэнх хороодод хийгдсэн ажил нь үр дүнгүй байсны улмаас хөрөнгө оруулалтын хяналтыг сайжруулах, хэрэгжиж дууссан ажлуудыг ондоо багтаан ашиглагч байгууллагын санхүүгийн тайланд тусгуулан эзэнжүүлэх шаардлагатай байна гэж дүгнэжээ.
- БХД-ийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны А/29 дугаар тогтоолоор хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсэг буюу хяналтын хороог байгуулжээ. Дээрх ажлын хэсэг нь 2021 оны 5 дугаар сарын 23-ны өдөр тус дүүрэгт хэрэгжсэн нийт 5 ТАХ-ний гүйцэтгэлд хяналт тавьж, хөрөнгө оруулалтын ажлын явц хэвийн хэмжээнд явагдаж байгаа ба илэрсэн ноцтой зөрчил дутагдалгүй гэж дүгнэсэн байна.
- СХД-ийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны А/20 дугаар тогтоолоор хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулжээ. Дүүргийн 2021 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-ний гүйцэтгэлд хийх хяналтыг 2022 оны 5 дугаар сарын 9-ны өдрөөс эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

Харин нийслэл болон БНД, БЗД, БГД, ХУД, ЧД-ийн ИТХ журамд заасан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлээгүй, бусад дүүргийн ИТХ нь ТАХ-ний зөвхөн гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлж, төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, бүртгэлд бүрэн

²³ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд ..нийслэл, .. дүүргийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо ...Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, ..нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина."

хяналт тавиагүй бөгөөд үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, тайланг тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлээгүй нь СС-ын 2021 оны журмын 9.8²⁴-д заасныг зөрчжээ.

Нийслэл, дүүргийн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд хууль, журмаа бүрэн гүйцэд судлаагүй, эрх зүйн актад заасан чиг үүргийн талаарх ойлголт хангалтгүйгээс хэрэгжилт дутмаг байна.

Дүгнэлт: Нийслэл болон 6 дүүргийн ИТХ нь ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлж, журамд заасан санхүүжилт олгох хөшүүргийг ашиглаж журмын хэрэгжилтийг хангаж ажилласан уу?

ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 2.2²⁵-т заасны дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, СС-ын 2018 оны 228 дугаар журмын 4.1²⁶-т заасны дагуу санхүүжилтийг олгохоор заажээ.

НОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хийгдсэн ТАХ-нд захиалагчийн хяналтыг дараах байгууллагууд хяналт тавьж ажиллажээ.

Хүснэгт №13. НОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, санхүүжилт олгосон байгууллагууд

| № | Байгууллагын нэр | Захиалагчийн хяналт тавьсан ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Олгосон санхүүжилт | Техник хяналтын зардал /сая.төг/ |
|---|------------------|---|-----------------|--------------------|----------------------------------|
| 1 | НАЗХГ | 38 | 3,915.3 | 3,001.3 | 20.6 |
| 2 | НХОГ ОНӨААТҮГ | 133 | 14,388.0 | 11,364.1 | 225.5 |
| 3 | НМЭГ | 1 | 205.9 | 203.8 | 0 |
| 4 | НЭМГ | 8 | 583.5 | 513.2 | - |
| 5 | НӨАУГ | 1 | 150.0 | 149.6 | - |
| 6 | НБГ | 2 | 254.0 | 75.0 | - |
| 7 | СХД | 20 | 2,130.0 | 1,832.8 | 39.8 |
| 8 | УБ Лифт | 1 | 10.0 | 9.9 | - |
| 9 | НМТГ | 3 | 489.0 | 84.5 | - |
| | Нийт | 207 | 22,125.7 | 17,234.2 | 285.9 |

Дээрх хүснэгтээс харахад захиалагчийн хяналтыг гэрээ байгуулсан 22,125.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 207 ТАХ-нд хэрэгжүүлж, 17,234.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос 285.9 сая төгрөгийг захиалагчийн техник, хяналтын зардалд зарцуулжээ.

ДОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд ЧД, БНД, СБД, БХД, НД-үүдэд тохижилт үйлчилгээний хэлтэс нь, СХД-т захиалагчийн алба нь, БЗД-т НХОГ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлжээ. Харин БГД-т “Хүн төвтэй хот төлөвлөлтийн лаборатори” НҮТББ захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

²⁴ 9.8.Энэ журмын 9.4, 9.5-д заасан байгууллага дангаараа болон иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлнэ.

²⁵ 2.2.Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

²⁶ 4.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг нь ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хуулийн 58 дугаарзүйлд заасан чиг үүрэгт хамаарах энэ журмын 4.2-т зааснаас бусад хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх ажлыг санхүүжүүлнэ.

Хүснэгт №14. ДОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ажилд захиалагчийн хяналт тавьж санхүүжилт олгосон байгууллагууд

/сая.төг/

| № | Нийслэл, дүүргийн нэр | Тах-ний тоо | Төсөвт өртөг | 2021 онд санхүүжсэн дүн | Гүйцэтгэгчид | Захиалагчийн техник хяналтын зардал | Зураг зохиогчийн хяналтын зардал | Магадлашгүй ажил | Гэрээний алданги | Барьцаа | ХАОАТ | Норм норматив |
|---|-----------------------|-------------|-----------------|-------------------------|----------------|-------------------------------------|----------------------------------|------------------|------------------|--------------|------------|---------------|
| 1 | БГД | 8 | 1,160.5 | 716.8 | 672.7 | 7.3 | 3.4 | 1.2 | 32.0 | 0.2 | | |
| 2 | БЗД | 35 | 2,904.1 | 1,080.3 | 1,000.0 | 19.7 | 3.7 | | 1.13 | 55.7 | | |
| 3 | СХД | 27 | 2,051.9 | 1,636.6 | 1,535.3 | 41.7 | | 11.5 | 6.8 | 41.3 | | |
| 4 | СБД | 20 | 827.4 | 688.1 | 641.2 | 11.5 | | | | 35.4 | | |
| 5 | ХУД | 4 | 1,446.2 | 0 | | | | | | | | |
| 6 | ЧД | 14 | 785.6 | 512.9 | 482.1 | | | | | 30.8 | | |
| 7 | БНД | 15 | 1,060.8 | 913.2 | 825.2 | 7.8 | | | | 80.2 | | |
| 8 | НД | 32 | 835.6 | 626.4 | 575.1 | | | | 3.1 | 45.1 | 3.1 | |
| 9 | БХД | 9 | 191.2 | 176.0 | 168.4 | 0.8 | | 0.4 | | 6.3 | 0.2 | |
| | Нийт | 164 | 11,263.3 | 6,350.3 | 5,900.0 | 88.8 | 7.1 | 13.1 | 43.0 | 295.0 | 3.3 | 4.8 |

Дээрх хүснэгтээс харахад захиалагчийн хяналтыг гэрээ байгуулсан 11,263.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 164 ТАХ-нд 6,350.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос 88.8 сая төгрөгийг захиалагчийн техник, хяналтын зардалд зарцуулжээ.

Нийт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-нд 23,584.5 сая төгрөг олгосноос захиалагчийн техник хяналтын зардалд нийт 374.7 сая төгрөг зарцуулжээ.

БНД-т ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд захиалагчийн хяналтыг тавьж хэрэгжүүлэхдээ 7.8 сая зарцуулснаас 2.5 сая төгрөгийг ДЗД-ын захирамжаар захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн болон байгууллагын бусад 9 албан хаагчийг урамшуулсан байна.

Мөн ТАХ-үүдийн хөрөнгө оруулалтын барьцааг авахдаа ТАХ тус бүрээр бус нийт дүнгээр нь шилжүүлсэн байна.

Дүгнэлт: Хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэлээс үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих ТАХ-ний захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлэхэд мэргэжлийн этгээдийг сонгох, гүйцэтгэл санхүүжилтийг тооцох шаардлагатай байгааг харуулж байна.

3.1.3. Хөндлөнгийн болон дотоод аудит, хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд өгсөн шийдвэрийн биелэлтийг хангаж, хяналтыг хэрэгжүүлж ажилласан уу?

СС-ын 2018 оны 228, 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан журамд орон нутгийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллагууд хяналт хэрэгжүүлэхээр зохицуулжээ.

ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл нь холбогдох хууль журамтай нийцэж буй эсэхэд 2020 онд НТАГ, 2021 онд НДАГ болон БГД, БНД, БХД, НД, СХД-үүдийн дотоод аудитын албанаас хяналт хэрэгжүүлж нийт 25 байгууллагыг хамруулан 1 акт, 2 албан шаардлагыг НТАГ, 35 зөвлөмжийг НТАГ болон бусад байгууллагаас хүргүүлж ажилласан байна. *Хавсралт 4*

Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж түүний биелэлтийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Акт:

- БЗД-ийн ЗДТГ-т барьцааг давхардуулан тооцож илүү шилжүүлсэн, хүү, торгуулийн орлогыг дутуу төвлөрүүлсэн үндэслэлээр төлбөр барагдуулах тухай НТАГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 01/106 НТАГ-2020 105/НА

дугаартай акт хүргүүлсэн. БЗД-ийн ЗДТГ-аас 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 04/1915 дугаар албан бичгээр 3.5 сая төгрөгийн актын төлбөрийг барагдуулсан талаар нотлох баримтын хамт ирүүлсэн.

Албан шаардлага:

○ ХУД-ийн ЗДТГ-т өмч бүртгэл, тоног төхөөрөмжийг өмч бүртгэлд хүлээн авах, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөхтэй холбоотой зөрчил арилгуулах тухай 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/133 НТАГ-2020/05/НА 1 албан шаардлага хүргүүлсний дагуу ХУД-ийн ЗДТГ-аас 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 05/2086 дугаар албан бичгээр камерын данс бүртгэлд бүртгэсэн, цаашид ашиглалт хамгаалалтад анхаарах талаар мэдэгдэж албан шаардлагыг биелүүлсэн байна.

○ БЗД-ийн ХААА-нд ХАА-тай холбоотой зөрчил арилгуулах тухай 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/132 НТАГ-2020/05/НА 1 албан шаардлагыг хүргүүлсний дагуу БЗД-ийн ХААА-аас 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 310 дугаар албан бичгээр зөрчлийг дахин давтахгүй байх талаар албан бичиг ирүүлсэн.

Зөвлөмж:

1. НТАГ-аас 2020 оны аудитын шалгалтаар Нийслэл, дүүргийн ИТХ-д 2, Нийслэл, дүүргийн ЗДТГ-т 3 зөвлөмж өгсөн.

Шалгагдагч байгууллагууд зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь ирүүлээгүй бөгөөд энэхүү аудитын явцад зөвлөмжийн биелэлтээ ирүүлсэн. Үүнээс дараах зөвлөмж хэрэгжээгүй. Үүнд:

- ЧД-ийн ЗДТГ-т “ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг хууль журмын дагуу тухай бүр нь бүртгэл тайланд бүрэн тусгах” зөвлөмж өгсөн боловч ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийг хууль, журмын дагуу одоог хүртэл бүртгэж тайлагнаагүй, өмч бүртгэл хийгээгүй;
- Нийслэл, дүүргүүдийн ИТХ-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагнал, бүртгэлийн явцад хууль тогтоомжид заасны дагуу хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх” зөвлөмж өгсөн боловч төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, бүртгэлд бүрэн хяналт тавиагүй, тайланг тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлээгүй байна.

2. НДАГ-аас 2021 оны 08 дугаар сард тухайн оны эхний хагас жилийн байдлаар улс, нийслэл, НОНХС-ийн эх үүсвэртэй ТАХ-нүүдэд дотоод аудит хийжээ.

НОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд нийт 306 ТАХ хэрэгжүүлэхээр батлагдсанаас 88 ТАХ-ний гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулагдсан, 218 ТАХ гэрээ байгуулагдах шатандаа явж байна. Ковидын нөхцөл байдлын улмаас зураг төсөл, техникийн нөхцөл боловсруулах, ХАА хойшлох, гүйцэтгэгч компани гэрээгээ цуцлах зэрэг шалтгаанаас ажил удаашрах, он дамжин хийгдэх эрсдэл бий болсон байна гэж дүгнэжээ.

3. БГД, БНД, БХД, НД, СХД-үүдийн дотоод аудитын албанаас ОНХС-ийн зарцуулалт холбогдох хууль, журамтай нийцэж буй эсэхэд аудит хийсэн байна. БНД, СХД-ийн ЗДТГ-ууд аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж хариу хүргүүлсэн. Бусад дүүргүүд зөвлөмжийн биелэлт гаргах хугацаа болоогүй, төлөвлөгөө гаргасан шалтгаанаар биелэлт ирүүлээгүй байна. Энэхүү аудитаар БНД, НД-үүдэд шаардлага хангаагүй гүйцэтгэгч сонгон шалгаруулсан зөрчил дахин давтагдан гарчээ.

Дээрх нөхцөл байдлыг дүгнэхэд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийг өмч бүртгэлд бүртгээгүй, ХАА зохион байгуулахдаа шаардлага хангасан гүйцэтгэгч сонгон шалгаруулаагүй зөрчлүүд давтагдаж байгаа нь өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийг бүрэн хангаагүй байгааг харуулж байна.

Дүгнэлт: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, зөрчлүүд дахин давтагдсаар байна.

3.2 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг холбогдох заавар, журмын дагуу тайлагнаж, хүргүүлсэн үү?

ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн тайланг журамд заасан хугацаанаас хоцроож, бүрэн тайлагнаагүй, зарим ТАХ-г нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байна. Мөн хэрэгжүүлж буй ТАХ-ний мэдээллийг УМС, шилэн дансны цахим нэгдсэн хуудаст цаг тухай бүр нь үнэн зөв, бүрэн мэдээллэх шаардлага бий болжээ.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг журам, зааврын дагуу тайлагнасан уу?

СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан журмын 9.2²⁷, 9.9²⁸-д заасны дагуу тайланг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заажээ.

Дүүргүүдийн ЭЗТХ-үүд ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг хүргүүлэхдээ журамд заасан зарим мэдээллийг тусгаагүй, хугацаа хоцроосон байна. Тухайлбал: Нийслэлийн 7 дүүрэг нь 2022 оны 3 дугаар сарын 25-30-ны хооронд буюу 55-60 хоногийн хугацаа хоцроон албан бичгээр хүргүүлсэн, СХД, БХД-ийн бодлого, төлөвлөлтийн хэлтсүүд хэрэгжилтийн тайланг албан бичгээр баталгаажуулж ирүүлээгүй байна.

Дээрх шалтгааны улмаас НЗДТГ-ын ХБТХ тайланг 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 01/1354 тоот албан бичгээр журамд заасан хугацаанаас 15 хоногоор хоцроож СЯ-д хүргүүлсэн байна.

Хэрэгжилтийн тайланг хүргүүлэхдээ олгосон санхүүжилтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар нэгтгээгүй буюу 2022 оны эхний улирлын байдлаар өссөн дүнгээр, журамд заасан зарим мэдээллийг оновчтой бүрэн мэдээллээгүй байна. Тухайлбал: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний цаашид хэрэгжүүлэх оновчтой санал, аудит болон хяналтын байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмж, акт, албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлагнаагүй байна.

***Дүгнэлт:** ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн тайланг хугацаа хоцроож, журамд заасны дагуу бүрэн тайлагнаагүй, журмын хэрэгжилт хангалтгүй байна.*

3.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв бүртгэж тайлагнасан уу?

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1²⁹-д заасны дагуу үнэлж дансанд тусгахаар заажээ.

Бүртгэгдвэл зохих 36,809.0 төгрөгийн төсөвт өртөгтэй 389 хөрөнгөөс 28,431.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 276 буюу 71%-ийг данс бүртгэлд тусгаагүй байна.

²⁷ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

²⁸ 9.9. Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст ирүүлэх бөгөөд тайланд дараах мэдээллийг багтаана. Үүнд:

9.9.1. ОНХС-ийн тухайн оны батлагдсан төсөв, санхүүжилт нь эх үүсвэр бүрээр;

9.9.2. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт нь хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр;

9.9.3. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр, байршил, ажлын гүйцэтгэлийн хувь, эхлэх, дуусах хугацаа;

9.9.4. Шинээр бий болсон барилга байгууламж, гүйцэтгэсэн их засварын ажил, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн фото зураг, тэдгээрийг өмчлөлд бүртгэснийг баталгаажуулсан баримт;

9.9.5. Он дамжин хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт;

9.9.6. ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн сайн туршлага, жишээ, оновчтой санал;

9.9.7. Энэ журмын 9.4, 9.5-д дурдсан байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, дүгнэлт, акт болон албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулга

²⁹ 9.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана."

**Хүснэгт №15. Хэрэгжсэн ТАХ-ээс
бүртгэлд тусгасан байдал**

/сая.төг/

| № | Дүүргийн нэр | Хөрөнгөнд бүртгэх ТАХ | | Бүртгэсэн ТАХ | | Бүртгээгүй ТАХ | |
|---|--------------|-----------------------|-----------------|---------------|----------------|----------------|-----------------|
| | | Тоо | Төсөвт өртөг | Тоо | Төсөвт өртөг | Тоо | Төсөвт өртөг |
| 1 | Нийслэл | 266 | 27,636.4 | 51 | 4,781.0 | 215 | 22,855.3 |
| 2 | БГД | 8 | 1,160.5 | 3 | 536 | 5 | 624.5 |
| 3 | БЗД | 35 | 3,019.2 | 10 | 541.9 | 25 | 2,477.3 |
| 4 | СХД | 27 | 2,051.9 | 18 | 1,012.9 | 9 | 1,039.0 |
| 5 | СБД | 12 | 496.7 | 9 | 358.4 | 3 | 138.3 |
| 6 | ЧД | 8 | 601.9 | 1 | 178.3 | 7 | 423.6 |
| 7 | НД | 10 | 568.1 | 6 | 273.9 | 4 | 294.2 |
| 8 | БНД | 14 | 1,046.5 | 8 | 487.9 | 6 | 558.6 |
| 9 | БХД | 9 | 227.8 | 7 | 206.8 | 2 | 21.0 |
| | Нийт | 389 | 36,809.0 | 113 | 8,377.1 | 276 | 28,431.8 |

Дээрх хүснэгтээс харахад 8,377.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 113 хөрөнгийг бүртгэж тайлагнажээ.

Харин хөрөнгөд бүртгээгүй 28,431.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 276 ТАХ-г бүртгээгүй шалтгааныг тодруулахад ажил хийгдэж дуусаагүй, он дамжиж хэрэгжиж байгаа, комиссын акт баталгаажаагүй, холбогдох албан тушаалтны хайхрамжгүй үйл ажиллагаа зэрэг шалтгаантай байна. Эдгээр ажлаас хэрэгжиж дууссан боловч хөрөнгийг бүртгэж аваагүй 1,890.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ байна. *Хавсралт 5. Тухайлбал:*

- 60 сая төгрөгийн төсөвт өртөгтэй автомашины зогсоол /СХД 18, 23-р хороо/
- 90.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бага хэмжээний авто зам, чулуун зам тавих /ЧД 12-р хороо/
- 400 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зам талбайн засвар, тохижилтын ажил /БЗД 16, 19, 24-р хороо/

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд ашиглалтад хүлээж авсан даруйд нь үнэн зөв бүртгэх, тайлагнах ажиллагаа удаашралтай байна.

3.2.3. Сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаар Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв оруулж, иргэдэд ил тод нээлттэй мэдээлсэн үү?

СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан журмын 10.2.1-д³⁰ заасны дагуу тухайн шатны ЗДТГ-ын холбогдох албан тушаалтан УМС-д тухайн онд батлагдсан ТАХ-ний мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор оруулахаар тусгажээ.

УМС-д байршуулсан мэдээллийг шалгахад 2021 онд хэрэгжих нийт 483 ТАХ-ээс 36 ТАХ буюу 7.4%-ийн мэдээллийг оруулсан байна.³¹

Хүснэгт №16. УМС-д мэдээлэл оруулсан байдал

| Нэр | УМС-д оруулах ТАХ-ний тоо | | | УМС-д оруулсан байгаа тоо |
|-----|---------------------------|--------------|------|---------------------------|
| | Он дамжсан ТАХ | 2021 оны ТАХ | Нийт | |
| НЗД | 137 | 155 | 292 | 0 |

³⁰ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тухайн шатны ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ОНХС-ийн УМС-д оруулна

³¹ <https://onhs.mof.gov.mn/>

| | | | | |
|------|-----|-----|-----|----|
| БГД | 2 | 6 | 8 | 6 |
| БЗД | 13 | 24 | 37 | 0 |
| БНД | 10 | 8 | 18 | 0 |
| БХД | 1 | 5 | 6 | 0 |
| НД | 6 | 30 | 36 | 13 |
| СБД | 4 | 17 | 21 | 17 |
| СХД | 19 | 14 | 33 | 0 |
| ХУД | 2 | 2 | 4 | 0 |
| ЧД | 5 | 23 | 28 | 0 |
| Нийт | 199 | 284 | 483 | 36 |

/2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар/

Нийслэл, дүүргийн ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудаас мэдээлэл оруулаагүй шалтгаан нөхцөлийг тодруулахад нийслэлд 2018 оноос “Смарт УБ” аппликейшнийг ашиглан санал асуулга авч тайлан мэдээг оруулж байсан, УМС-ийн сайт нь ажиллахгүй, гацсан, хөгжүүлэлт хийгдэж байгаа зэрэг шалтгааны улмаас журмыг хэрэгжилтийг хангаагүй байна. Одоо тухайн сайтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа тул журамд заасан ажлаа хийж гүйцэтгэх шаардлагатай байна. Аудитын явцад БГД, СБД-үүд 2021 онд хэрэгжсэн 23 ТАХ-ний мэдээллүүдийг бүрэн оруулсан.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалт, ТАХ-ний талаарх мэдээллийг байршуулдаг сайт, програмын шинэчлэлт, өөрчлөлттэй холбоотойгоор УМС-д сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнгийн талаарх мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

3.2.4. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цаг тухай бүрт нь мэдээлсэн үү?

Шилэн дансны тухай хуулийн 6.1.1³², 6.1.2³³, 6.3.9³⁴ -т заасны дагуу ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаарх төлөвлөгөөг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор мэдээллэхээр заасан.

ДОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллээс шалгахад ЧД нь 2021 оны ОНХС-ийн төлөвлөгөөгөө оруулаагүй, НД-ээс бусад дүүрэг хугацаа хоцруулж мэдээлсэн байна. Тухайлбал:

Хүснэгт №17. Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцруулж оруулсан дүүргүүд

| № | Нийслэл, дүүргийн нэр | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | Бүтэн жил | Нийт |
|---|-----------------------|----------|-------|-------|-------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|----------|-----------|-----------|
| 1 | БГД | | | | | | | | | | 1 | | | | 1 |
| 2 | БЗД | | | | | | | | | | | 1 | | | 1 |
| 3 | БНД | 1 | | | | | | | 1 | | 1 | | | | 3 |
| 4 | БХД | 1 | | | | | | 1 | | | | 1 | 1 | | 4 |
| 5 | НД | | | | | | | | | | | | | 1 | 1 |
| 6 | СБД | | | | | | | | | | 1 | | | 1 | 2 |
| 7 | СХД | 1 | | | | | | | | 1 | | | | | 2 |
| 8 | ХУД | | | | | 1 | 1 | 1 | | | | | | | 3 |
| 9 | ЧД | | | | | | 1 | | | 1 | | | | | 2 |
| | Нийт | 3 | | | | 1 | 2 | 2 | 1 | 2 | 3 | 2 | 1 | 2 | 19 |

Тайлбар: 1-Хугацаа хоцроосон

³² 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

³³ 6.1.2.хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

³⁴ 6.3.9.орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.

Дүүргүүд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл оруулж байгаа хэдий ч оруулсан мэдээлэл нь бүрэн бус, хангалтгүй байна. /БНД, СБД, ЧД-үүд олгосон санхүүжилт, шилэн дансны мэдээллийг зөрүүтэй оруулсан/

Иймд ОНХС-ийн мэдээллээ бүрэн гүйцэд, үнэн зөв оруулж хэвших шаардлагатай байна.

Дүгнэлт: ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтын талаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллээ бүрэн оруулаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

